



**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

2024 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

СӨҮЛ ХОТ

2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАСАГ

I. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ:

1. БНСУ-д Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн харилцааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1.1.1 Хөдөлмөрийн гэрээт ажилчдад өмнө нь тогтмол хийдэг байсан “ирсний дараах сургалт” 2020 оноос хойш зогссон байсныг сэргээх чиглэлээр БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү хот дахь Олон улсын сургалтын төвтэй харилцан тохиролцооноор, хичээлийн агуулгыг шинэчилж танхимын сургалтыг тогтмолжуулав.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирж буй 456 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг 14 удаа цахимаар, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү хот дахь Олон улсын сургалтын төвд ирсний дараах сургалтыг танхимаар 12 удаа 395 гэрээт иргэнд, нийт 26 удаагийн сургалтад давхардсан тоогоор 851 хөдөлмөрийн гэрээт ажилчныг хамруулан дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв. Үүнд:

- Төвийн үйл ажиллагааны танилцуулга
- Цалин хөлс тооцох, ажлын байр солих талаар
- Үйлдвэрлэлийн ослын даатгал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ослоос урьдчилан сэргийлэх тухай
- Солонгос Улсын хууль, журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
- Ур чадвартай ажиллах хүчний Е-7-4 визний талаар
- Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал гэх зэрэг.

1.1.2 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2024 онд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт **3866** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлэн өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажилласан.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү, нутаг буцах зардал, үйлдвэрлэлийн ослын даатгал, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс зэрэг хэлбэрээр нийт **928,661,160.00** воныг Монгол Улсын **187** иргэнд олгуулсан.

Хүснэгт 1: Ажил үйлчилгээний төрлөөр иргэдэд олгуулсан мөнгөн дүнгийн жагсаалт

Ажил үйлчилгээний төрөл		Мөнгөн дүн /won/
Хөдөлмөрийн гэрээт ажилчид	Буцах замын зардал	30,240,620.00
	Цалин, илүү цагийн хөлс	31,890,015.00
	Самсунг даатгал дахь 13 дахь сарын цалин	345,496,650.00
	Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалин	103,436,024.00
	Үйлдвэрлэлийн ослын даатгал	156,529,516.00
	Гэнэтийн ослын даатгал	45,069,197.00
	Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад	26,427,435.00
Бусад төрлийн	Олгогдоогүй, хойшлогдсон цалин хөлс	9,930,000.00

виз	Үйлдвэрлэлийн ослын даатгал	2,287,520.00
	13 дахь сарын цалин	4,339,602.00
Хууль бусаар оршин суудаг иргэдэд	13 дахь сарын цалин	500,000.00
	Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	15,591,131.00
	Үйлдвэрлэлийн ослын даатгал	8,168,480.00
	Эмнэлгийн үнэ төлбөргүй үйлчилгээ болон бусад	60,000,000.00
НИЙТ ОЛГУУЛСАН ДҮН		928,661,160.00

2. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаад хугацаа нь дуусаж буй хөдөлмөрийн гэрээт иргэдийг хугацаандаа нутаг буцахад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

1.2.1 Тайлант хугацаанд хөдөлмөрийн гэрээт ажилчдын ажлын байр болон бүс нутгуудад очин санал хүсэлтийг сонсох, хууль бусаар оршин суухын хор уршиг, хугацаандаа нутаг буцах талаар мэдээлэл зөвлөгөө өгөх зорилгоор 2024 онд Пажү, Дэгү, Нунсан, Дэжон, Игсан, Жэжү, Бүсан хотын 11 компанийн 134 хөдөлмөрийн гэрээт ажилчны ажлын байранд очиж нөхцөл байдалтай танилцав. Үүнд:

- 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Пажү хотын “Гисог трэйдиг” компанид ажиллаж байгаа 15 гэрээт ажилчинд;
- 2024 оны 03 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд БНСУ-ын Дэгү, Нунсан, Дэжон, Игсан хотын 4 компанид ажиллаж байгаа 27 гэрээт ажилчинд;
- 2024 оны 08 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд Жежү хотын 4 компанид ажиллаж амьдарч буй 80 ажилчинд;
- 2024 оны 11 дүгээр сарын 14, 15-ны өдөр БНСУ-ын Бүсан хотын 3 үйлдвэрийн 12 ажилчинд тус тус хөдөлмөрийн харилцаа, холбогдох хууль тогтоомж, хугацаандаа нутаг буцах буюу Е-7-4 виз рүү хөрвөх талаар мэдээлэл зөвлөгөө өгч, хөдөлмөрийн аюулгүй байдлын гарын авлагыг хүргэн ажилласан.

1.2.2 Хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусах дөхсөн 73 хөдөлмөрийн гэрээт ажилчинтай утсаар холбогдон тулгамдсан асуудал, санал хүсэлтийг нь сонсож, хууль бусаар оршин суухаас сэргийлж, хугацаандаа нутаг буцахыг зөвлөн 568 гэрээт иргэнд 1950 масс мессеж илгээж мэдээлэл хүргэсэн. Хууль бусаар оршин суухын хор уршиг, суугаа орны хууль, дүрэм, журмын шинэчлэлийг таниулж, хугацаандаа нутаг буцахыг зөвлөн цахим хуудсаар 13, сошиал хуудсаар 28 удаагийн мэдээлэл хүргэсэн. Тухайлбал, хууль бусаар оршин сууж буй иргэдийг сайн дураар нутаг буцах өршөөлийн хууль зарлагдсан тухай мэдээллийг 5 удаа, хууль бус иргэдийн баривчилгаа аян зарлагдсан тухай мэдээллийг 4 удаа иргэдэд хүргэсэн ба 2024 онд хууль бусаар оршин сууж байсан 58 иргэний сайн дураар нутаг буцах мэдэгдлийг БНСУ-ын Цагаачлалын албанд гаргаж өгсөн.

3. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр тогтвор суурьшилтай ажиллан ур чадвартай ажиллах хүчний визний ангилал руу шилжүүлэх ажлын хүрээнд:

1.3.1 Е-7-4 визний асуудлаар нийт 206 иргэнд бүрдүүлэх баримт бичиг, оноо цуглуулах, гэр бүлээ урих, ТОПИК шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх, визний ангиллаа дараагийн ангилал руу өөрчлөх зэрэг мэдээлэл зөвлөгөө өгч, оноо тоолох болон орчуулга хийх зэргээр визний ангиллаа солиход нь дэмжлэг үзүүлэв. Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор видео контент 3, мэдээ 3, ярилцлага 1, постер 2 тус тус бэлтгэн төвийн веб сайт сошиал хуудсанд нийтэлсэн. Энэ хүрээнд Солонгосын Хууль зүйн яамны харьяа Гадаадын иргэн харьяатын албаны 1345 лавлах төвд хүсэлт тавьж ярилцлага бэлтгэн монголчуудын идэвхтэй ашигладаг сошиал группүүдээр түгээснээр 20,638 хүнд хүрсэн.

Е-7-4 визний асуудлаар Солонгосын Хууль зүйн яамны харьяа Гадаадын иргэн харьяатын албаны 1345 лавлах төвийн зөвлөх Ц.Цэнд-Аюуштай ярилцлага

хийж төвийн веб сайт, сошиал хуудсанд нийтэлсэн ба 14,218 хүнд хүрсэн. Мөн ур чадвартай ажилчны виз мэдүүлэх журамд орсон өөрчлөлтийн мэдээг орчуулан, постер бэлтгэж мэдээлсэн.

4. БНСУ-д оршин сууж байгаа монгол гэр бүл, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлж, дэмжин туслах ажлын хүрээнд:

1.4.1 Хилийн чанадад оршин суугаа Монгол Улсын үнэт зүйл болсон гэр бүл, хүүхэд залуус, иргэдийнхээ дуу хоолойг сонсох, хэрэгцээ шаардлагад нийцсэн нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэх зорилготой “Монгол гэр бүл” өдөрлөгийг БНСУ-ын Сөүл хотноо 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан ба Монгол Улсын яам агентлагийн төлөөлөгч, албан хаагчид, БНСУ-д үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага нэгдлүүдийн төлөөлөл, Солонгос Улсын төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид, Монгол улсын иргэд, хүүхэд багачууд нийт 270 хүн оролцов. Өдөрлөгийн хүрээнд гар зургийн уралдаан зарлаж шилдэг оролцогчдод шагнал гардуулсан.

Солонгост амьдарч буй монгол хүүхдүүдийг төрөлх хэлээ эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор БНСУ дахь Монгол хэл бичиг, соёлын төв НҮТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, ням гараг бүр 40 хүүхдийг хамруулан төвийн байранд сургалт хичээллүүлж байна. Сургалтын нээлтийг 2024 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Сөүл хотын захиргааны байранд зохион байгуулж хүүхдийн эрх, хамгаалал, хөгжилтэй холбоотой мэдээллийг 120 хүүхэд, эцэг эхчүүдэд хүргэсэн.

1.4.2 БНСУ-д оршин суугаа Монгол Улсын 247 иргэнд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлснээс ганцаарчилсан сэтгэл засалд 207 хүн, бүлгийн сэтгэл засалд 40 хүнийг хамруулсан. Сэтгэл зүйн байдлыг илрүүлэх, зан төлөвийг үнэлэх зорилгоор нойрны өөрчлөлт илрүүлэх сорил 63 хүнд, гутралыг илрүүлэх сорил 63 хүнд, түгшилтийг илрүүлэх сорил 60 хүнд, ажлаас халшрах хам шинжийн сорил 24 хүнд, архины хамаарал илрүүлэх сорил 13 хүнд, картын аргыг 16 хүнд, өнгөний сорилыг 12 хүнд тус тус хийж зөвлөгөө өгсөн.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАСАГ

2. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

1. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд хамруулах ажлын хүрээнд:

2.1.1 Тайлант хугацаанд нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд 410 иргэнийг шинээр хамруулан “Солонгос Улсад гэрээгээр ажиллагсдын программ”-д мэдээллийг бүртгэн гэрээ байгуулсан. Мөн нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэдэд шинээр 434, гэрээний хугацаа сунгасан 263, ажлын байраа сольсон, гэрчилгээг гэж үрэгдүүлсэн, албан байгууллага нь хүсэлт гаргасан 85, нийт 782 даатгуулагчид Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг тус тус бичиж олгосон.

2. БНСУ-д хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн визний ангиллаар оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах ажлын хүрээнд:

2.2.1 Нийт 462 иргэнийг сайн дурын нийгмийн даатгалд шинээр хамруулж, БНСУ-ын ААН-д хөдөлмөр эрхэлдэг 444 даатгуулагчийн хүсэлтийн дагуу Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын

Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг бичиж олгосон.

3. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, тайлагнах ажлын хүрээнд:
2.3.1 НДЕГ-ын даргын 2024 оны А/02 дугаар тушаалаар тус тасгийн 2024 оны орлогын батлагдсан төлөвлөгөө 4,997,799,000.00 төгрөг, сар бүрийн орлогын төлөвлөгөө 416,483,250.00 төгрөг болно. Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 61,5 хувиар биелүүлсэн бөгөөд хүснэгт 2-оор харуулбал:

Хүснэгт 2: Шимтгэлийн орлого төвлөрүүлэлт 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

Сар	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого	Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь
		Вон	Төгрөг	Төгрөг	Вон	Төгрөг	
12	4,997,799,000.00	578.402.299.00	1,446,982,844.96	1,624,992,661.74	578.402.299.00	3,071,975,506.70	61,5

2.3.2 Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын ажил олгогчдод тухайн сарын болон өмнөх саруудын 4830 ширхэг шимтгэл төлөх нэхэмжлэл факсаар илгээн, нийт 7,734 даатгуулагчтай шимтгэл төлөхийг сануулж, утсаар холбогдсон.

4. Тэтгэмж авах эрх үүссэн даатгуулагчдад баримт олгох ажлын хүрээнд:
2.4.1 Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол нөхцөлийг хангасан, нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх үүссэн 61 даатгуулагчид шаардлагатай бичиг баримтыг монгол хэлнээ хөрвүүлж, зохих журмын дагуу даатгуулагчийн тодорхойлолтыг гаргаж өгсөн.

5. Иргэд, даатгуулагчид болон ажил олгогчдод нийгмийн даатгалын талаар мэдээлэл, заавар, зөвлөгөө өгөх, тэдний хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлын хүрээнд:
2.5.1 Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 14,100, үүнээс 13,867 иргэн, даатгуулагч, ажил олгогчид утсаар, 233 иргэн, даатгуулагчид биечлэн Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад төрлийн мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч, сурталчилгааны материал тараан ажилласан.

6. БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанаас шимтгэлийн буцаан олголтыг олгуулах ажлын хүрээнд:
2.6.1 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар хүсэлт ирүүлж, ҮТА-д илгээснээс 26 ээлжийн 73 иргэний хүсэлтийг шийдвэрлэж, 351,200,000.00 воныг олгуулсан.

3. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

1. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сахилга хариуцлагыг чангатгах, ажлын бүтээмж, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн ажлын хүрээнд:
3.1.1 Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” сошиал хуудсанд 160 удаа, байгууллагын <https://seoulcenter.mlsp.gov.mn> цахим хуудсанд 113 удаагийн мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилснаар 467,293 орчим хандалт авсан.
3.1.2 Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улс, БНСУ-ын төрийн болон сургалтын

байгууллагуудаас зохион байгуулсан 34 удаагийн сургалтад төвийн албан хаагчдыг хамруулсан. Тухайлбал,

- БНСУ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хэрэг эрхлэх газрын аюулгүй ажиллагааны туршлага судлах сургалтад 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр;
- БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн боловсролын институтын мэргэшүүлэх сургалтад 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр;
- Авлигатай тэмцэх газрын “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх цогц сургалт” 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр;
- Удирдлагын академийн "Төрийн албан хаагчийг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх сургалт" 2024 оны 12 дугаар сарын 02,03-ны өдөр;
- Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтад нийт 22 удаа хамрагдаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн.

3.1.3 Тайлант хугацаанд БНСУ-ын төрийн байгууллагууд болон тус улсад үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсын төр, хувийн хэвшлийн нийт 22 байгууллагатай гадаад хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажилласан.

3.1.4 Нийгмийн даатгалын аппликейшнд бүртгүүлэх 86 иргэний хүсэлтийг хүлээн авч, бүртгэлийг баталгаажуулан, иргэдэд бүртгүүлэх кодыг холбогдох программаас илгээв. Мөн нийгмийн даатгалын лавлагаа авах хүсэлт гаргасан 157 иргэний хүсэлтийн дагуу мэдээллийг холбогдох программаас гаргаж өгөв.